



Empowered lives.
Resilient nations.

Хурлын тэмдэглэл

НҮБХХ-ДДБОС: “Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн байгалийн нөөцийн нэгдсэн менежмент” (Төсөл)

Оросын Холбооны Улс ба Монгол Улс

Төслийн Удирдах Зөвлөлийн бүсийн 2 дах хуралдаан

Улаанбаатар, Монгол улс

4 сарын 27, 2013

Хурлын дарга: ноён В. Мамаев НҮБХХ/ ДДБОС-гийн бүс нутгийн техникийн зөвлөх, НҮБХХ-ийн Братислав дах Бүсийн Төв

Нарийн бичиг: Англи хэл дээр (Уриел Хэскиа)
Монгол хэл дээр (Төмөрчөдөр Содном)
Орос хэл дээр (Лариса Д.Раднаева)

Хөтөлбөр: Хавсралт 1

Оролцогчдын нэрсийн жагсаалт: Хавсралт 2

Төслийн Удирдах Зөвлөлийн бүсийн 2 дах хуралдааны зорилго нь:
Төслийн 2012 оны хийсэн ажлын үр дүнгийн болон 2013 оны ажлын төлөвлөгөө, төсвийг
Төслийн Удирдах Зөвлөлийн гишүүд болон ажиглагчдад тайлагнах, Хил Дамнасан
Оношлогоо Дүн Шинжилгээний ажил болон хоёр улсын хил дамнасан усны хамтын
ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, цаашид сайжруулах
боломжийн талаарх саналуудыг танилцуулах



Empowered lives.
Resilient nations.

Төслийн Удирдах Зөвлөлийн бүсийн 2 дах хуралдаан 2013 оны 4 сарын 27-ны өдөр Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа.

Хурлын нээлт

Хурлыг нээн НҮБХХ/ДДБОС-гийн бүс нутгийн техникийн зөвлөх (НҮБХХ-ийн Братислав дах Бүсийн Төв) ноён Владимир Мамаев үг хэлж, хурлын зорилго болон оролцогчдын талаар товч мэдээлэл хийлээ.

Хуралд оролцогчидтой мэндчилж Төслийн Үндэсний Захирал, БОНХЯ-ны Төрийн Нарийн Бичгийн Дарга ноён Ж.Батболд (Монгол улс); НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгч, хатагтай Сэзин Синаноглу; Байгаль нуур төслийн үндэсний зохицуулагч ноён Александр А.Шеховцов (Төслийн Үндэсний Захирал, ОХУ-ын Байгалийн Нөөц, Экологийн Яамны Байгалийн Нөөцийн Удирдлагын Холбооны Албаны дарга ноён М.Амирхановыг төлөөлж); НҮБ-ын ТҮА-ны Портфолио ассистент, ноён Уриел Хэскиа; БНБУ-ын Эрхүү мужийн Байгалийн Нөөцийн Хяналтын Албаны дарга (ОХУ), ноён Константин Г.Дремов; БНБУ-ын Байгалийн Нөөцийн Яамны Сайд (ОХУ), ноён Баир Д.Ангаев; Эрхүү мужийн Байгалийн Нөөц ба Экологийн Яамны Сайд (ОХУ), ноён Олег Е.Кравчук болон Енисей Мөрний Сав Газрын Усны Менежментийн Захиргааны дарга, ОХУ-ын Холбооны усны нөөцийн агентлаг (ОХУ), ноён Владимир К.Благов нар үг хэлэв.

Байгаль нуур төслийн 2012 оны ажлын үр дүн

Илтгэлийн эхэнд төслийн менежер С.Куделя Байгаль нуур төслийн 2012 онд хийсэн ажлын тайланг ТУЗ-ийн гишүүдэд 2013 оны эхэнд явуулсныг дурьдлаа.

Дараа нь төслийн менежер С.Куделя Байгаль нуур төслийн 2012 онд хийсэн ажлын үр дүн болон зардлын талаар илтгэл тавьлаа.

Төслийн 2012 онд хийхээр төлөвлөсөн ажлын хүрээнд Москва, Улаанбаатар, Иркутск, Улаан үд, Чита, Ростов на Дону хотуудын төрийн эрдэм шинжилгээний байгууллагууд болон төрийн бус байгууллагаас нийт 17 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2012 онд хийж гүйцэтгэсэн ажилд усны нөөцийн менежмент, гадаргын ба газрын доорх усны харилцан үйлчлэл, уул уурхай, аялал жуулчлалын нөлөөнөөс биологийн төрөл зүйлийг хамгаалах, Байгаль нуурын сав газар дах бохирдлын халуун цэгүүд, Байгаль нуурын нутаг дэвсгэр дэх уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, оролцогч талуудыг сургаж, чадавхижуулах зэрэг чиглэлээр ОХУ, Монголын талаас нийт 13 бие даасан судлаачид оролцож ажилласан байна.

Түүнээс гадна олон улсын судлаачидтай хамтарсан 3 гэрээ байгуулан ажиллаж байна.



Empowered lives.
Resilient nations.

Төслийн зорилго, чиглэлтэй холбоотой 29 үйл явдалд төслийн баг хамт олон оролцож, хамтран ажилласнаас гадна төслийн үйл ажиллагааны талаар 50 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан мэдээлэл хүргэсэн байна.

Төслийн веб хуудас нээгдэж, Орос, Монгол, Англи хэл дээр байнга шинэчлэгдэж байдаг. Веб хуудаснаас дээрх гурван хэл дээр мэдээллийг татаж авах боломжтой (RSS channels).

Төслийн эхний жилийн төсвийн гүйцэтгэл 95.41% байна. Төслийн 2012 оны батлагдсан төсөв 1 084.275 USD байснаас 2012 оны сүүлчээр төсвийн зардал 1 034 484.45 USD болсон.

Үр дүн 1: Нийт төсөв: \$404 156.20 Зардал: \$486 312.97

Хил Дамнасан Оношлогоо, Дүн Шинжилгээний нарийвчилсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлын ихэнхи хэсгийг 2012 онд хийсэн бөгөөд одоо төслийн баг сайжруулах, эмхэтгэх, орчуулах ажлыг гүйцэтгэж байна. Хил Дамнасан Оношлогоо, Дүн Шинжилгээний ажлын хүрээнд нэмэлт судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба үүнд: а) Сэлэнгэ мөрний цутгал орчмын усны чанарын судалгаа б) Сэлэнгэ мөрний цутгал орчмын орчны болон бентосын бүсийн судалгаа с) ХДОДШ-ийн газрын доорх усны нөөцийн үнэлгээ d) Халуун цэгүүдийн үнэлгээ f) Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа. Мөн биологийн төрөл зүйлийг хамгаалах стандарт боловсруулах, сайжруулах, дэд сав газруудын (ОХУ-ын Төгнөй Сухара, Хилок гол, Монгол улсын Идэр, Эг ба Орхон гол) менежментийн төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх ажлыг 2012 онд гүйцэтгэж эхэлсэн байна.

Үр дүн 2: Төсөв: \$246 618.86 Зардал: \$242 852.27

Төслөөс Бүрэн эрхт төлөөлөгчдийн уулзалт болон ажлын хэсгийг дэмжиж хамтран ажилласан. Хоёр улсын хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, цаашид сайжруулах боломжийн талаарх концепци болон саналыг боловсруулсан. Сава голын сав газрын Усны комиссийн жишээнээс суралцах, туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. Байгаль нуурын сав газрын усны бохирдуулагч бодисын зөөгдлийг загварчлах ажлын мэдээллийн санг боловсруулсан ба Сэлэнгэ мөрний сав газрын усны чанарын уялдуулсан мониторингийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үр дүн 3: Төсөв: \$326 469.00 Зардал: \$202 329.09

Үр дүн 3-ын хүрээнд Байгаль нуурын Мэдээллийн Төв байгуулах ажлын концепцийг боловсруулсан бөгөөд БНМТөвийн веб хуудсыг нээсэн. Хоёр орны талд өөрийгөө хөгжүүлэх, үнэлэх судалгааны ажлын арга зүйг гаргаж авсан бөгөөд одоо төслийн зөвлөхүүд нь УННМ-ийн оролцогч талуудын хүрээнд судалгаа хийх бэлтгэл ажлыг хийж байна.

Экологийн боловсролыг дээшлүүлэх сургалтын хоёр төлөвлөгөөг ОХУ боловсруулан гаргасан.

Үхсэн малын сэг зэмийг булшлах ажлын стратегийг гаргасан. Захиргааны ажилчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. Байгаль нуурын шим мандлын нөөц газрын болон Забайкальскийн Байгалийн Цогцолборт Газрын аялал жуулчлалын төлөвлөгөөг боловсруулан гаргасан.

Олон нийттэй харилцах, мэдлэгийг дээшлүүлэх ажлын төлөвлөгөөг хоёр орон бэлтгэж гаргасан. Эцэст нь байгаль орчны бохирдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

ажлын хүрээнд ОХУ, Монголын талд гол нуурын эрэг орчмын цэвэрлгээ хийх кампанийг ажлыг зохион байгуулсан.

Төслөөс гарах үр дүн	Нийт төсөв (USD)	Зардал 2011+2012	Төсөв 2013	Төсвийн баланс
Үр дүн 1: Стратеги бодлого ба төлөвлөлтийн үндэс				
	\$ 917 930.00	\$ 486 312.97	\$ 232 470.69	\$ 199 146.34
Үр дүн 2: : УННМ-ийн бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх				
	\$ 751 534.00	\$ 242 852.27	\$ 213 222.11	\$ 295 459.62
Үр дүн 3: Усны чанар, биологийн төрөл зүйлийн менежментийг бодлогод тусгах арга, аргачлалын үзүүлэн сургалт.				
	\$1 844 174.00	\$ 202 329.09	\$ 604 327.44	\$1 037 517.47
Төслийн менежмент	\$ 384 362.00	\$ 102 990.12	\$ 90 670.73	\$ 190 701.15
Бүгд	\$3 898 000.00	\$1 034 484.45	\$1 140 690.97	\$1 722 824.58

Хүснэгт 1. Байгаль нуурын төслийн төсөв ба зардал.

Төслийн бүх үр дүн ба тайлангууд төслийн веб хуудас дээр тавигдсан болно.

Дараагийн хэсэгт Байгаль нуур төслийн Оросын үндэсний зохицуулагч Ноён Александр А.Шеховцов, Монголын үндэсний зохицуулагч Хатагтай Содномын Төмөрчөдөр нар хоёр оронд хийгдсэн төслийн ажлын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй илтгэл тавив.

НҮББШУСБ-ын Байгалийн ухааны секторын усны шинжлэх ухааны салбарын хөтөлбөрийн мэргэжилтэн, Хатагтай Зандарьяа Сарантуяа төслийн хүрээнд НҮББШУСБ-ын хийж байгаа ажлын талаар илтгэл тавив.

Илтгэлүүдийн дараа БНБУ-ын Байгалийн Нөөцийн Яамны Сайд (ОХУ), Ноён Баир Д.Ангаев Монголын талд Сэлэнгэ мөрөн дээр барихаар төлөвлөж буй Шүрэнгийн УЦС-ын экологийн эрсдэлийн үнэлгээг төслийн хүрээнд хийхийг санал болгов.

Монголын талын төлөөлөгчдийн тэргүүн санал гаргасанд талархан иймэрхүү эрсдэлийг анхаарч тооцож байгааг хэлээд энэ ажлыг төслийн хүрээнд авч үзэх бус Монгол улсын ЗГ хариуцан шийдэх асуудал гэдгийг дурьдлаа.

Үүний дараа Төслийн Үндэсний Захирал Ноён Ж.Батболд (Монгол улс) өөрийн эрхийг БОНХЯ-ны ГХХАХ-ийн дарга Ноён Д.Батболдод шилжүүлж өөр газар яаралтай уулзалтанд оролцохоор явлаа.

Хил Дамнасан Оношлогоо Дүн Шинжилгээний ажлыг хянан үзэх

Хурлын үеэр Хил Дамнасан Оношлогоо Дүн Шинжилгээний тайлангийн төслийг бүх оролцогчдод хүргүүлсэн.



Empowered lives.
Resilient nations.

Доктор Саскиа Марайнссен Хил Дамнасан Оношлогоо Дүн Шинжилгээний ажил ба Стратеги Үйл Ажиллагааны Хөтөлбөрийн (SAP) талаар танилцуулга хийлээ.

Тэрээр ХДОДШ ба СҮАХ хоорондоо хэрхэн уялдах талаар тодорхой тайлбарлаад, Байгаль нуурын сав газарт байгаа асуудлыг эрэмбэлэх, Шалтгааны уялдаат шинжилгээ нь ХДОДШ-ний ажлын үндэслэл болох талаар, мөн ХДОДШ-г авч хэлэлцэх зөвөлгөөний үеэр гарсан судалгааны ажлын талбайг өөрчлөх санал болон 2014 оны 9-10 дугаар сард хоёр орны Засгийн газраар дэмжигдэн батлагдах СҮАХ-ийг хийх арга замын талаар танилцуулав.

Дугуй ширээний ярилцлагын үеэр зарим асуудлын талаар авч үзлээ:

- ХДОДШ-ний ажил нь шинжлэх ухааны судалгааны ажил дээр суурилсан бөгөөд гэрээ хэлэлцээрийн баримт бичиг бус бөгөөд хоёр орны судлаачдын тогтоосон хил дамнасан шинж чанартай асуудлыг тодорхойлсон мэдээлэл бүхий баримт бичиг юм. Эдгээр асуудлыг эрэмбэлэх ажлыг хоёр орны судлаачид хийж гүйцэтгэсэн.
- ХДОДШ-ний ажил нь төслийн УЗ-өөр батлагдах шаардлагагүй.
- Харин ХДОДШ-ний ажил дээр үндэслэгдэн батлагдах СҮАХ нь улс төрийн, хэлэлцээрийн бичиг баримт болох юм. Тийм учраас ХДОДШ-ний ажилд өгөх төслийн УЗ-ийн гишүүдийн санал шүүмж чухал юм.
- Төслийн УЗ-ийн гишүүд нь 4 долоо хоногийн дотор ХДОДШ-ний ажилд санал шүүмж өгсний дараа СҮАХ-ийг боловсруулах ажлын үндэслэл болох ХДОДШ-ний ажлын эцсийн хувилбарыг боловсруулна.
- Үүний дараа төслийн УЗ-ийн гишүүдийн санал болон санааг тусган оруулж, ХДОДШ-г шинэчлэх ажлыг мэргэжилтэнгүүд 4 долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2013 оны 6 дугаар сарын сүүлчээр ХДОДШ-ний төслийн шинэчилсэн хувилбарыг бэлтгэж гаргана.
- Дараагийн шатанд хоёр орны ЗГ-ын байгууллагууд 2013 оны 7,8 дугаар сар буюу 2 сарын хугацаанд ХДОДШ-ний ажилд санал шүүмжийг тусган оруулж, эцсийн хувилбарыг бэлтгэнэ.
- Төрийн захиргааны байгууллагын саналыг тусгаж сайжруулсны дараа ХДОДШ-ний эцсийн хувилбарыг 2013 оны 9 дүгээр сард хэвлэлтэнд бэлэн болгоно.
- ХДОДШ –д эрэмбэлэгдсэн асуудал 1 “*Modification of Hydrological Flows*” гэж орсныг “*Change of Hydrological Flows*” болгож оруулах
- Эхний гурван асуудлын эрэмбийг ижил тэнцүү гэж ойлгон дараах байдлаар оруулна:
1. Усны ба эх газрын амьдрах орчны доройтол 2. Усны нөөц, горимын өөрчлөлт 3. Усны чанарын доройтол.

Хил орчмын байгаль орчныг хамгаалах болон усны менежментийн чиглэлээр Орос-Монголын хамтын ажиллагааг сайжруулах

Хуулийн мэргэжилтэн Ноён Сергей Виноградов ОХУ, Монгол улсын байгаль хамгаалах болон усны менежментийн чиглэлээр хамтран ажиллахад хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, цаашид сайжруулах боломжит хувилбарын талаар илтгэл тавьлаа (Хавсралт 3).

Доктор Сергей Виноградов хоёр улсын хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, сайжруулах хоёр хувилбарыг санал болгов:

- Санал 1. Одоо байгаа гэрээ хэлэлцээрийг хэвээр үлдээж, зарим асуудлыг нэмэлт тодруулга хийж оруулах (нэмэлт протокол хийх) замаар шийдэх [Энэ аргыг ОХУ, Казакстаны асуудлыг шийдэхэд хэрэглэсэн]



Empowered lives.
Resilient nations.

- Санал 2. Одоо байгаа гэрээ хэлэлцээрийн дутагдалтай талуудыг сайжруулсан бүтэц бүхий механизмийг тусгасан шинэ гэрээ хэлэлцээрийг боловсруулах

Илтгэлийн дараах дугуй ширээний ярилцлагын үеэр дараах асуудлын талаар авч үзлээ:

- Хоёр орны засгийн газраас гарын үсэг зурсан төслийн баримт бичигт 1995 онд байгуулсан Орос, Монгол улсын хоорондын Хил дамнасан усыг хамгаалах, ашиглах (ОУХА) хоёр талын гэрээг сайжруулах шаардлага байгааг тусгасан. Шинэ гэрээ хэлэлцээр байгуулж, шинэ комиссийг чадавхижуулах талаар оруулсан ч төслийн УЗ-ийн өнгөрсөн удаагийн хуралдааны үеэр Төслийн Үндэсний Захирал Ноён Ц.Бадрах Засгийн газрын зүгээс хуучин гэрээ хэлэлцээрийн хууль эрх зүйн болон институцийн хүрээг хэвээр үлдээх саналтай байгааг онцлон хэлсэн. Тиймээс 2012 онд төслийн хүрээнд одоо байгаа хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн бүтцийг хариуцагч бие бүрэлдхүүний мэдлэг чадварыг дээшлүүлэх тал дээр дэмжиж ажиллаж ирсэн.
- Хуулийн мэргэжилтэн өргөн хүрээг хамарсан дүн шинжилгээний анализ хийж, төслийн УЗ-ийн гишүүдэд санал зөвлөмж гаргаж өгсөн.
- Хурлын явцад төслөөс зөвхөн НҮБХХ ба ДДБОС-ийн туршлага дээр үндэслэсэн зөвлөмжийг хоёр орны засгийн газарт санал болгох ба шинэчлэл хийхийг тулгахгүй гэдгийг тэмдэглэв. Эцсийн шийдвэрийг төслийн хүрээнд бус, харин хоёр орны эрх бүхий байгууллагын хүрээнд гаргах ёстой.
- Хэлэлцсэний эцэст төслийн УЗ-ийн гишүүдийн зүгээс хоёр дах саналыг дэмжиж олон улсын туршлага, хилийн ус болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр гарч байгаа хандлагыг тусгасан “Хил орчмын байгаль орчныг хамгаалах болон усны менежментийн чиглэлээр Орос-Монголын хамтын ажиллагаа”-ны төслийг боловсруулахыг даалгав. Уг баримт бичгийг хоёр орны засгийн газар анхааралдаа авч үзэх юм.

Байгаль нуур төслийн 2013 оны ажлын төлөвлөгөө ба төсөв

Илтгэлийн эхэнд төслийн менежер С.Куделя Байгаль нуур төслийн 2013 оны ажлын төлөвлөгөө ба төсвийг төслийн УЗ-ийн гишүүдэд 2013 оны эхэнд явуулсныг дурьдлаа. Түүнчлэн Ноён С.Куделя төслийн үйл ажиллагаа төслийн баримт бичигт тусгагдсаны дагуу ямар нэгэн гажилтгүйгээр явж байгааг тайлбарлав.

Дараа нь төслийн менежер С.Куделя 2013 оны ажлын төлөвлөгөө ба төсвийг Үр дүн 1-ийн хүрээнд задалж тайлбарлав. Үр дүн 1-ийн санал болгож буй төсөв **\$232 470.69**.

ХДОДШ-ний ажлын 95% бэлэн болсон. Энэ хурлын дараа ТУН-ээс мэргэжилтэнгүүдтэй хамтран гаргасан санал, зөвлөмжийн дагуу сайжруулж 2013 оны 5 сарын сүүлээр бэлэн болгоно.

Голын цутгал хэсэгт 2012 оны төслийн ажлын хүрээнд тодорхойлогдсон усны станцууд дээр усны чанарын байнгын ажиглалт хийгдэнэ. ХДОДШ-ийн газрын доорх усны нөөцийн үнэлгээ, гадаргын ба газрын доорх усны харилцан үйлчлэл ба газрын доорх уснаас хамааралтай экосистемийн судалгаа ба Сэлэнгэ мөрний сав газарт байрлах цэвэрлэх байгууламжуудыг сайжруулах төслийн судалгаа, Хараа голын сав газрын бохирдлын үнэлгээ зэрэг ажлуудыг 2013 оны 6 дугаар сард дуусгана.

2013 онд төслийн хүрээнд СҮАХ-г хийх ажлын хэсгийг батлах ба СҮАХ-ийн төслийг боловсруулна.



Empowered lives.
Resilient nations.

ОХУ-д мөрдөгдөж байгаа бодлогын болон норм стандартанд орчин үеийн шинэ туршлага, практикт тулгуурлан анализ хийх ба биологийн олон янз байдлыг хамгаалахтай холбогдсон орон нутгийн болон үндэсний хэмжээний бодлого, хууль эрх зүйн болон бүсийн хөгжлийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн талаар зөвлөмжүүдийг боловсруулна.

Бүс нутгийн, ялангуяа Эрхүү ба Буриадад хэрэгжүүлэх аялал жуулчлалын төлөвлөгөөнд эко туризм ба бохирдлоос хамгаалах асуудлыг санал болгон дэвшүүлнэ.

ОХУ ба Монголын талд дэд сав газруудын (ОХУ-ын Төгнөй Сухара, Хилок гол, Монгол улсын Идэр, Эг ба Orkhon гол) менежментийн төлөвлөгөө боловсруулж бэлтгэнэ.

Төслийн менежментийн нэгжээс 2012 онд боловсруулсан хэд хэдэн баримт бичиг, тухайлбал хянан тохиолдуулсан ХДОДШ болон сургалтын материалыг хэвлэн гаргах болно.

Хурлын дарга Ноён В.Мамаев 2013 оын ажлын төлөвлөгөө ба төсвийн Үр дүн 1-тэй холбоотой асуулт байгаа эсэхийг лавлав.

Ноён Д.Батболдоос нэг санал гарсан нь 2013 оын ажлын төлөвлөгөө ба төсвийг төслийн УЗ-ийн хурлын дараа Монголын талын төлөөллийн тэргүүн Ноён Ж. Батболдод танилцуулж дэмжсэний дараа батлах, хурлын протоколыг бүх талууд үзэж хүлээн зөвшөөрсөн байх ёстой гэж хэллээ.

Дараа нь төслийн менежер С.Кудея, 2013 оын ажлын төлөвлөгөө ба төсвийг Үр дүн 2-ийн хүрээнд задалж тайлбарлав. Үр дүн 2-ийн санал болгож буй төсөв **\$213 222.11**.

Төслөөс Бүрэн эрхт төлөөлөгчдийн уулзалтын үйл ажиллагааг дэмжиж ажлаа үргэлжлүүлнэ.

Төслийн хүрээнд одоо байгаа хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн бүтцийг хариуцагч бие бүрэлдхүүний мэдлэг чадварыг дээшлүүлэх тал дээр дэмжиж ажиллаж ирсэн.

Хоёр орны засгийн газраас гарын үсэг зурсан төслийн баримт бичигт 1995 онд байгуулсан Орос, Монгол улсын хоорондын Хил дамнасан усыг хамгаалах, ашиглах (ОУХА) хоёр талын гэрээний ажлын хэсгийг дэмжиж ажиллана.

Төслөөс хоёр орны хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, цаашид сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

Өөрийгөө хөгжүүлэх, үнэлэх судалгааны ажлын сургалтын материалыг боловсруулан гаргаж, тусгай сургалтуудыг зохион байгуулна.

Сэлэнгэ мөрний гадаргын усны чанарын судалгаанд сонгогдсон үзүүлэлтээр хоёр талд ижил арга зүйгээр хэмжилт явуулж, интеркалибраци хийнэ.

Сэлэнгэ мөрний сав газрын чухал цэгүүдэд бохирдуулагч бодисын зөөгдлийн хэмжээг загварчлах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Төслийн менежментийн нэгжээс 2012 онд боловсруулсан баримт бичгүүд, тухайлбал усны чанарын уялдуулсан мониторингийн хөтөлбөр болон сургалтын материалыг хэвлэн гаргана.

Хурлын дарга Ноён В.Мамаев 2013 оны ажлын төлөвлөгөө ба төсвийн Үр дүн 2-той холбоотой асуулт байгаа эсэхийг лавлав.



Empowered lives.
Resilient nations.

Эхний хэсгийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу ажлын төлөвлөгөөний үр дүнгийн хэсгийн 2.1 дэх хэсгийн текстийг : “Хил дамнасан усны хамтын ажиллагааны хууль эрх зүйн болон институцийн хүрээг хөгжүүлэх, сайжруулах” гэснийг өөрчлөн: “Байгаль орчныг хамгаалах болон усны менежментийн чиглэлээр Орос-Монголын хамтын ажиллагаа”-ны “гэрээний төслийг бэлтгэх “ гэж оруулах

Үүний дараа төслийн менежер С.Куделя, 2013 оын ажлын төлөвлөгөө ба төсвийг Үр дүн 3-ын хүрээнд задалж тайлбарлав. Үр дүн 3-ын санал болгож буй төсөв **\$\$604 327.44**.

Уул уурхайгаас биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлийн туршилтын төслүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд: а) Холодинскийн орд газрын шүүрлийн усыг цэвэрлэх технологийн шийдэл боловсруулах ба шүүрлийн усыг цэвэрлэх геохимийн цэвэрлэгээний хаалт болон ус хуримтлуулах сангийн дизайныг боловсруулах зөвлөмж гаргах; б) Алтны шороон ордыг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах технологийн шийдлийг боловсруулах; с) Уул уурхайн үйлдвэрлэлийн хог хаягдлыг аюулгүй хадгалах болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин боловсруулах замаар Джидинскийн зэс вольфрамын үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

Малын сэг зэмийг хадгалах стратегит заасан зөвлөмжийн дагуу малын сэг булшлах хоёр газрыг Буриад улсын Курумхан болон Баргузинд байгуулна.

Байкал-Ленскийн нөөц газрын биологийн олон янз байдалд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

Мөн Буриад улсын Яристо тосгоны дэргэд Баргузины Буддын сүмийн дэргэдэх Янжма бурхны чулуун дүрсийн ойр орчимд биологийн олон янз байдалд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

Байгаль нуурын биосферийн байгалийн нөөц газарт иж бүрэн эко аялал зохион байгуулна.

Спортын загас агнуурын туршилтын хөтөлбөрийг бэлтгэж, зохион байгуулна.

2012 онд байгуулагдсан Байгаль нуурын Мэдээллийн Төвийн үйл ажиллагааг 2013 онд төслөөс дэмжиж ажиллах ба програм болон тоног төхөөрөмжөөр хангана. Үүнээс гадна Байгаль нуурын сав газрын Экологийн атласыг боловсруулна.

Байгаль нуурын Мэдээллийн Төвийн хүрээнд хил дамнасан “Байгаль нуурын нөхөд” ТББ-ын сүлжээ байгуулж, дэмжиж ажиллана.

Олон нийтийн ухамсрыг Байгаль нуурын хил дамнасан асуудалд хандуулах, боловсролыг дэмжих зорилгоор “Хил хязгааргүй Байгаль нуур” баримтат кино хийх ба гол мөрний эрэг дагуу цэвэрлэгээ хийх кампанит ажлыг зохион байгуулна.

Хурлын дарга ноён В.Мамаев 2013 оын ажлын төлөвлөгөө ба төсвийн Үр дүн 3-тай холбоотой санал, асуулт байгаа эсэхийг лавлав.

Санал асуулт гараагүй.

2013 оны нийт төсвийн хэмжээг дээр дурьдсан “Хүснэгт 1 Байгаль нуур төслийн төсөв ба зардал”-д харуулсан болно.

Дараа нь төслийн менежер С.Куделя төслийн баримт бичигт оруулах шаардлагатай өөрчлөлтийн талаар танилцуулав.



Empowered lives.
Resilient nations.

Санал болгож буй өөрчлөлт1: Төслийн бичиг баримтанд зардлын хэмнэлттэй хөвөгч дээр байрлуулсан хэмжилтийн багажийг суурилуулахад дэмжлэг үзүүлэхээр заасан. Хамтрагч талуудтай зөвлөлдөхөд нуурын ус жил бүр хөлддөг, эдгээр багажийг тээвэрлэх завь аль аль улсад нь байхгүй байна.

Хуудас 41

168. Төслийн бичиг баримтанд зардлын хэмнэлттэй хөвөгч дээр байрлуулсан хэмжилтийн багажийг суурилуулахад дэмжлэг үзүүлэхээр заасан. Хөвүүр ашигласнаар цагийн өндөр нарийвчлалтай мониторингийн аргаар температур, уусмал хүчилтөрөгч зэрэг параметруудийг авч болно. Хөвүүрийг хавар байрлуулж, намар авах тул завь ашиглах хугацааг цомхотгож, эдийн засгийг үр ашгийг дээшлүүлдэг. Энэ үйл ажиллагаагаар нуур судлаачдын олон улсын нийгэмлэгийн хөвүүр ашигладаг мэдлэг, туршлагаас суралцах болно: <http://gleon.org>.

хуудас72

Төсвийн тэмдэглэл. Усны чанарын хөвөгч багаж (50k); Өөрчлөлтийн хандлагыг тодорхойлоход шаардагдах хээрийн хэмжилтийг энгийн багаж төхөөрөмжүүд

Оруулах өөрчлөлт: Энэ мөнгийг (50K ам доллар) зөвхөн Монголын талд усны чанарын уялдуулсан хөтөлбөрийн хүрээнд гарсан зөвлөмжид тусгасны дагуу УЦУОХүрээлэнгийн усны чанарын лабораторид шаардлагатай байгаа ионы хроматографийг худалдан авахад зориулна.

Санал болгож буй өөрчлөлт 1-ийн талаар гаргасан шийдвэр: Төслийн удирдах зөвлөлийн гишүүд өөрчлөлтийн саналыг дэмжиж, нэмэлт саналуудыг хэлсэн. Төслийн менежер С.Куделя худалдан авах тоног төхөөрөмжийн сонголтын талаар Монголын талын мэргэжилтэнгүүдтэй хэлэлцэж ярилцана. Хөвсгөл нуур дээр цаг уурын станц хэрэгтэй талаар санал гарч байсан ба худалдан авах үнэ 50 000 ам доллараас бага байна.

Санал болгож буй өөрчлөлт 2: Стратегийн үр дүнгийн хүрээнд Хөвсгөл нуурын экосистемийн дасан зохицох байдлыг хангах үзүүлэлтийг оруулсан байдаг. Жил бүрийн хэмжилтийн мэдээний хөтөлбөрт эдгээр үзүүлэлтүүд ороогүй байдаг. Монголын хувьд Хөвсгөл нуур дээр цаг уурын нэг станцтай бөгөөд нуурын эргэн тойронд анхаарал татах үйлдвэрийн газар, халуун цэг байдаггүй. Мөн нутгийн зан заншлын онцлогоос хамаарч хувийн ба үйлдвэрийн загас агнуур төдийлөн хөгжөөгүй. Загас нь Монголын үндэсний хоол зоогт ордоггүй. Загасны нөөцийн үнэлгээ хийгдэж байгаагүй ба төслийн хүрээнд хээрийн хэмжилт судалгаанд зориулагдсан хөрөнгө тусгагдаагүй.

х.63 Стратегийн үр дүнгийн хүрээ

<p>Хөвсгөл нуурын экосистемийн дасан зохицох байдлыг ханган, усны чанар муудах эрсдлийг бууруулах.</p> <p>- Тэжээллэгийн концентрац: уусмал реактив фосфор/хлорофил-а</p> <p>- Секкийн гүн буюу үзэгдэх гүн [1]</p>		<p>Зорилтот түвшин:</p>	<p>Жил бүрийн хяналт шинжилгээний өгөгдөхүүн.</p>	<p>Гадаад хүчин зүйлс үр дүнд нөлөөлж болзошгүй (үйлдвэрийн тунадас, бохирдол).</p>
---	--	-------------------------	---	---



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

<p>- Хөвсгөлийн хадран загасны тоо, насны бүтэц [2]</p>	<p>SRP: 0.5-2; Chl-a: 0.2-1[3]</p> <p>16-20 м</p> <p>Төслийн эхний зун.</p>	<p>Уусмал реактив фосфор, хлорофил-а: түвшин өсөөгүй;</p> <p>Секкийн гүн: багасаагүй.</p> <p>Хадран загасны тоо, насны бүтэц суурь түвшиндээ.</p>		
---	---	---	--	--

Оруулах өөрчлөлт: Стратегийн үр дүнгийн хүрээнээс эдгээрийг хасах.

Санал болгож буй өөрчлөлт 2-ийн талаарх шийдвэр: Төслийн удирдах зөвлөлийн гишүүд өөрчлөх саналыг дэмжсэн.

Өөрчлөлт оруулах гурав дах хэсгийг ярихын өмнө төслийн менежер биологийн олон янз байдлыг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанууд зөвхөн Оросын талд явагдах ба үр дүнг мэдлэг туршлагаа хуваалцах, жишээ болгох үүднээс Монголын талтай хуваалцах болно гэдгийг мэдэгдсэн.

Санал болгож буй өөрчлөлт 3: Байгаль нуурын сав газрын Оросын талд уул уурхай, аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй. Үзүүлэлтийн тоо хэмжээг бууруулах шаардлагатай.

х.64 Стратегийн үр дүнгийн хүрээ

<p>ОХУ, Монгол Улсын нутаг дахь Байгаль нуурын сав газарт биологийн олон төрөл, экосистемийн тэсвэрт байдлын зорилтыг агуулсан # тооны бодлого журмыг үйлдвэрлэлийн салбарт мөрдөж байна.</p>	<p>Биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглах арга хэмжээг 10 бодлого, журамд тусгаж өөрчилнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлал: ОХУ дахь зорилтот гурван газар хэрэгжиж байгаа буюу хэрэгждэггүй жуулчлалын хянан сайжруулсан төлөвлөгөө. - Уул уурхай: улс тус бүрт хоёроос доошгүй, нийт дөрвөн бодлогыг шинэчилнэ. - Спорт загасчлал: ОХУ-д хоёр тусгай хамгаалалттай газар нэгээс доошгүй бодлого журмаа шинэчилнэ. - Усны хагалбарын менежмент төлөвлөгөө: менежмент төлөвлөлтийн нэгээс доошгүй бодлого шинэчлэгдэнэ.
<p>Давтан хэрэгжилтийг хэмжих тоо: биологийн төрөл зүйлийн асуудлыг ОХУ, Монгол Улс дахь аялал жуулчлал, уул уурхайн # компани практик үйл ажиллагаандаа тусгасан.</p>	<p>Монгол Улсад 10-с доошгүй, ОХУ-д 10-с доошгүй уул уурхайн компани. Монгол Улсад 15-с доошгүй, ОХУ-д 15-с доошгүй аялал жуулчлалын компани.</p>

Оруулах өөрчлөлтүүд:



Empowered lives.
Resilient nations.

1. Өгүүлбэрийг “Уул уурхай: Улс бүрт 2 уурхайн, нийт 4” гэснийг “Уул уурхай: ОХУ-д 2” болгож өөрчлөх.
2. Replace sentence “Давтан хэрэгжилтийг хэмжих тоо: биологийн төрөл зүйлийн асуудлыг ОХУ, Монгол Улс дахь аялал жуулчлал, уул уурхайн # компани практик үйл ажиллагаандаа тусгасан” гэснийг “Давтан хэрэгжилтийг хэмжих тоо: биологийн төрөл зүйлийн асуудлыг ОХУ дахь аялал жуулчлал, уул уурхайн # компани практик үйл ажиллагаандаа тусгасан” гэж оруулах
3. Өгүүлбэр “Монгол Улсад 10-с доошгүй, ОХУ-д 10-с доошгүй уул уурхайн компани” гэснийг “ОХУ-д 5-с доошгүй уул уурхайн компани” гэж оруулах.
4. Өгүүлбэр “Монгол Улсад 15-с доошгүй, ОХУ-д 15-с доошгүй аялал жуулчлалын компани” гэснийг “ОХУ-д 15-с доошгүй аялал жуулчлалын компани” гэж солих.

Санал болгож буй өөрчлөлт 3-ийн талаарх шийдвэр: Төслийн удирдах зөвлөлийн гишүүд өөрчлөлтийн саналыг дэмжсэн.

Санал болгож буй өөрчлөлт 4: Тул загас нь Улаан номд бүртгэгдсэн төрөл зүйл. ОХУ-д тулыг агнахыг хуулиар хориглосон байдаг.

хуудас 44

182. *b) Байгаль нуурын сав газарт нөлөөлөл багатай, мэдрэмжтэй спорт загасчлалын жуулчлалын загвар хөтөлбөр боловсруулах, туршиж. Дэлхийн ихэнх хэсэгт спорт загасчлал нь загасыг “барих, хороохын” нэр байдаг. Загасчлах гэдэг нь загасыг хороох гэсэн утгатай. Түүгээр ч зогсохгүй далайн спорт загасчлалд ч энэ нь тулгамдсан асуудал болсон ба тэр тусмаа Байгаль нуурын сав газар адил гол мөрний загасны популяцийн тогтвортой, эрүүл байдлыг хангахад ч бэрхшээл учруулдаг. “Барих, хороох” зарчмаар загасчилсны уршгаар илүү эрэлттэй (мөн экологийн ач холбогдол өндөртэй) томоохон загасны популяци эрс багассан. Байгаль нуурын сав газарт тул, зэвэг, хадар загасны бүлгэмдэл огцом цөөрч, зарим хэсэгт жамаараа нөхөн төлжих боломжтой хэмжээнээс багасч, гол мөрний экологийн тэнцвэр өөрчлөгдөхөд хүргэж байна.*

183. Гэтэл Байгаль нуурын савын Монголын хэсэгт загасыг “барих, тавих” спорт загасчлалын хэлбэрийг амжилттай туршиж хэрэгжүүлсэн туршлага байх агаад үүнд жуулчдыг голын алслагдсан салаанд аваачиж, тул загас бариулж, эргүүлэн тавиулдаг байна. Энэхүү хөтөлбөр нь шинжлэх ухааны үндэслэлтэй бөгөөд олон жилийн турш радио, хиймэл дагуул, акустикийн аргаар тулын экологийг судалж, “барих, тавих” загасчлал тул загасны популяцийн тоо толгой, шилжилт хөдөлгөөн, түрс шахах хугацаа, хооллолт, насны бүтцэд хэрхэн нөлөөлсөн байдлыг тодорхойлсон байна¹. Загасчид өөрсдөө барьж, тавьсан загасныхаа талаарх мэдээллийг тэмдэглэдэг. Орон нутгийн олон нийтэд ч энэ хөтөлбөр ашиг тус өгч байгаа бөгөөд загасчлал зохион байгуулдаг компани ба орон нутгийн олон нийтийн хооронд албан ёсны гэрээ байгуулах ажил үргэлжилж байна.

184. Энэ туршилтад ажил мэргэжил нэгтний сургалт гол байр эзэлнэ. Загасыг “барих, тавих” жуулчлалын амжилттай хэрэгжиж буй наанадаж нэг жишээнд түшиглэж хоёр улсын аялал жуулчлалын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч ажилтнууд, спорт загасчлалын аяллын хөтөч, оператор нарт сургалт зохион байгуулна. Спорт загасчлалын хөтөч нарын бүлгүүд зохион байгуулж, загасыг уургаар бариад тавих зарчмын талаар сургалтад хамруулна. Мөн загасыг барих, тавих үед хэрхэн харьцах арга техникийг үзүүлнэ. Мөн энэ туршилтын хүрээнд Байгаль нуурын сав газрын бариад тавих загасчлалын хөтөч нарын холбоо байгуулж, бодлого хэрэгжүүлэх, чадавхи бэхжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулна.

¹ Jensen, O.P., et. al. 2009. Evaluating recreational fisheries for an endangered species: a case study of taimen, *Hucho taimen*, in Mongolia. *Canadian Journal of Fisheries Aquatic Sciences*. **66**: 1707–1718.



Empowered lives.
Resilient nations.

Оруулах өөрчлөлт: Спорт загас агнуурын хөтөлбөрт зөвхөн хуулиар агнахыг зөвшөөрсөн төрөл зүйлийг хамруулна.

Санал болгож буй өөрчлөлтийн талаарх шийдвэр 4: Төслийн удирдах зөвлөлийн бүх гишүүд өөрчлөлтийн саналыг дэмжсэн.

Эцэст нь төслийн удирдагч УННМ-ийг хэрэгжүүлэхэд хамгийн шаардлагатай хэрэгслэлүүдийн нэг болох Усны балансын загварчлал хийхийг санал болгосон. Тэрээр Монголын Сэлэнгэ мөрөн дээр байгуулах далангийн ажлын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах урьдчилсан судалгааны ажлыг хэрэгжүүлэх хамтарсан төслийг Дэлхийн Банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр хийхийг санал болгов. Дэлхийн Банкны төлөөлөгч ноён Рикард Лиден Төслийн Удирдах Зөвлөлийн хуралдаанд оролцов. Байгаль нуурын төслийн зүгээс Оросын талд загварчлал хийх ажлыг дэмжинэ.

Энэ санал нь Төслийн удирдах зөвлөлөөр дэмжигдсэн ч НҮБХХ/ДДБОС-гийн бүс нутгийн техникийн зөвлөх ноён Владимир Мамаев Дэлхийн Банкны хамтарсан санхүүжилтээр хийгдэх учраас энэ талаар сүүлд дахин мэдээлнэ гэж тайлбарлав.

Төслийн менежер С.Куделя Дэлхийн Банктай харилцах ажлаа үргэлжлүүлэх ба төслийн УЗ-ийн ийн гишүүд энэ саналыг дэмжиж, чухал болохыг тэмдэглэв.

Хуралдааны хаалт

Ноён В.Мамаев хурлыг хаахын өмнө Төслийн удирдах зөвлөлийн бүсийн гурав дах хуралдааныг 2014 оны 6 дугаар сард Байгаль нуурын орчимд хийхийг санал болгов. Төслийн менежер С.Куделя төслийн удирдах зөвлөлийн гишүүдэд Байгаль нуур төслийн 2013 онд хийсэн ажлын тайланг танилцуулж, 2014 оны ажлын төлөвлөгөө, төсвийг танилцуулах болно. Энэ асуудал дээр санал, асуулт гараагүй.

Цаашлаад ноён В. Мамаев 2014 онд төсөл дундаа орох учраас төслийн дунд шатны үнэлгээг бие даасан зөвлөхүүдээр хийлгэх болно гэж мэдэгдлээ.

Тавигдсан илтгэл, мэдээлэл, ярилцлагын үр дүнд үндэслэн Төслийн удирдах зөвлөлөөс дараах шийдвэрүүдийг гаргав:

1. Төслийн 2012 онд хийсэн ажлын үр дүн ба зардлын талаарх мэдээлэлийг хүлээж авах
2. Хянан үзсэн ХДОДШ-ний ажлын талаарх мэдээллийг хүлээж авах
3. Хуралд оролцогчид нь ХДОДШ-ний ажилд 4 долоо хоногийн дотор санал, шүүмж хийх. Төслийн удирдах зөвлөлийн гишүүдийн санал болон санааг тусган оруулж, ХДОДШ-г шинэчлэх ажлыг мэргэжилтэнгүүд 4 долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. 2013 оны 6 дугаар сарын сүүлчээр ХДОДШ-ний төслийн шинэчилсэн хувилбарыг бэлтгэж гаргана. Дараагийн шатанд 2 орны Засгийн газрын байгууллагууд 2013 оны 7,8 дугаар сар буюу хоёр сарын хугацаанд ХДОДШ-ний ажилд санал шүүмжийг тусган оруулж, эцсийн хувилбарыг бэлтгэнэ. Төрийн захиргааны байгууллагын саналыг тусгаж сайжруулсны дараа ХДОДШ-ний эцсийн хувилбарыг 2013 оны 9 дүгээр сард хэвлэлтэнд бэлэн болгоно.
4. Төслийн удирдах зөвлөлийн гишүүдийн зүгээс хоёр дах саналыг дэмжиж олон улсын туршлага, хилийн ус болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр гарч байгаа хандлагыг тусгасан “Байгаль орчныг хамгаалах болон усны менежментийн чиглэлээр



Empowered lives.
Resilient nations.

- Орос-Монголын хамтын ажиллагаа”-ны гэрээний төслийг боловсруулахыг даалгав. Ут баримт бичгийг хоёр орны засгийн газарт танилцуулахаар өргөн барих.
5. Төслийн 2013 оны ажлын төлөвлөгөө ба төсөвд төслийн УЗ-өөс гарсан санал зөвлөмжийг дагуу нэмэлт өөрчлөлтийг оруулж, сайжруулсны дараа батлах
 6. Төслийн баримт бичигт оруулж байгаа дөрвөн өөрчлөлтийг зөвшөөрөх талаар санал нэгдэх
 7. Хуралд оролцогчид нь албан ёсны баримт бичгүүдэд өгөх санал шүүмжээ ажлын 10 хоногийн дотор ирүүлэх
 8. Төслийн удирдах зөвлөлийн бүсийн гурав дах хуралдааныг 2014 оны 6 дугаар сард Байгаль нуурын орчимд ОХУ-д зохион байгуулах